



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор  
2025 оны 03 дугаар сарын 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Н.Батчимэг  
Утас: 91113253 Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ИЗТЗБАХ	Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2/87  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв томилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020428

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 160.18 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 313,726.96 мянган төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 712 дугаар тогтоолоор “ДҮТ” ТӨХХК-аас худалдан авах цахилгааны тарифыг 241.92 төгрөг, түгээх үйлчилгээний төлбөр буюу тарифыг 1,973,282.35 мянган төгрөг болгон өөрчлөн баталсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь 2024 онд зорилтот түвшний гүйцэтгэлээр 18,112,601.9 мянган төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн, нийт зардал 16,539,855.9 мянган төгрөг баталж, 17,096,444.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба цалин, урамшуулал 282,039.9 мянга, ажиллагсдын нийгмийн зардал 13,410.6 мянга, албан томилолтын зардал 5,119.6 мянга, дулааны зардал 15,248.3 мянга, төлөөлөн удирдах зөвлөлийн зардал 15,883.3 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК -ийн үйл ажиллагааны тайланг Төлөөлөн удирдах зөвлөл үнэлээгүй байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРВҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02

2025 11 06 16:25:02



2025 11 06 16:25:02



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	491,516,844.40	1,171,867,318.35
1.1.2	Дансны авлага	1,188,603,601.17	1,973,364,340.40
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.03	1,457,102.01
1.1.4	Бусад авлага	65,087,153.01	66,668,885.91
1.1.6	Бараа материал	1,430,371,627.57	1,064,038,985.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	406,066,612.57	592,616,708.85
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,581,645,838.72	4,870,013,341.01
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,926,702,789.03	20,496,479,202.31
1.2.2	Биет бус хөрөнгө	447,308,560.75	448,713,039.29
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	20,374,011,349.78	20,945,192,241.92
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>23,955,657,188.50</b>	<b>25,815,205,582.61</b>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	90,161,847.43	25,810,707.63
2.1.1.2	Цалингийн өглөг	0.10	1,442,530.98
2.1.1.3	Татварын өр	99,199,490.07	341,564,418.25
2.1.1.4	НДШ-ийн өглөг	85.77	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,242,174.76	30,669,162.61
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	(0.01₮)	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	200,603,598.13	399,486,819.47
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	468,461,713.99	427,882,429.03
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	468,461,713.99	427,882,429.03
2.2	Өр төлбөрийн нийт дүн	669,065,312.12	827,369,248.50
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,426,737,382.97	1,426,737,382.97
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,027,341,582.02	5,027,341,582.02
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,673,854,879.36	19,377,652,774.12
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,841,341,967.97₮)	(843,895,405.00₮)
2.3.11	Эздийн өмчийн дүн	23,286,591,876.38	24,987,836,334.11
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>23,955,657,188.50</b>	<b>25,815,205,582.61</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	13,842,895,405.95	18,112,601,913.17
2	Борлуулалтын өртөг	9,313,740,723.73	11,904,588,030.80

**"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	Нийт ашиг (алдагдал)	4,529,154,682.22	6,208,013,882.37
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	1,299,270.29	974,720.89
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	519,142,407.42	521,929,968.63
9	Борлуулалт, маркетингийн зардал	893,798,073.02	1,155,562,944.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,415,862,132.04	4,009,401,310.86
11	Санхүүгийн зардал	5,202,688.10	4,758,550.84
12	Бусад зардал	420,031,747.95	406,415,983.46
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(5,923,000.89₮)	(46,505,823.56₮)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	308,778,717.92	1,108,273,958.86
19	Орлогын татварын зардал	₮ 30,877,871.79	110,827,395.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	277,900,846.13	997,446,562.97
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	277,900,846.13	997,446,562.97
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	277,900,846.13	997,446,562.97
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	₮ 0.00

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,308,501,265.78	15,131,526,672.33
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,724,481,700.99	14,837,700,802.62
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	671,061.60	-
	Татаас, санхүүжилтийн орлого	110,000.00	-
	Бусад мөнгөн орлого	583,238,503.19	293,825,869.71
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,854,011,896.38	14,411,538,763.97
	Ажиллагчдад төлсөн	1,657,293,170.25	2,388,115,054.52
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	558,454,608.32	764,865,327.37
	Бараа материал худалдан авахад төлсөн	784,631,500.00	5,595,047,630.00
	Ашиглалтын зардалд төлсөн	108,889,596.22	163,878,594.87

**"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	72,337,385.00	93,586,050.00
	Хүүний төлбөрт төлсөн	2,375,292.43	2,471,396.73
	Татварын байгууллагад төлсөн	530,208,552.10	710,952,457.71
	Даатгалын төлбөрт төлсөн	53,423,788.58	12,857,100.00
	Бусад мөнгөн зарлага	8,086,398,003.48	4,679,765,152.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	454,489,369.40	719,987,908.36
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,408,250.70	898,113.07
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	6,000,000.00	-
	Хүлээн авсан хүүний орлого	408,250.70	898,113.07
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,621,378.88	20,245,905.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	18,621,378.88	20,245,905.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,213,128.18)	(19,347,791.93)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	20,289,642.48
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	20,289,642.48
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(20,289,642.48)
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	442,276,241.22	680,350,473.95
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,240,603.18	491,516,844.40
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	491,516,844.40	1,171,867,318.35

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,125,737,100.71	(2,119,242,814.09)	20,460,573,251.61
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,125,737,100.71	(2,119,242,814.09)	20,460,573,251.61
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	277,900,846.13	277,900,846.13
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	2,548,117,778.65	-	2,548,117,778.65
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	18,673,854,879.36	(1,841,341,967.95)	23,286,591,876.38
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	18,673,854,879.36	(1,841,341,967.97)	23,286,591,876.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	997,446,562.97	997,446,562.97
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	703,797,894.76	-	703,797,894.76
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	19,377,652,774.12	(843,895,405.00)	24,987,836,334.11

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

(төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Мөр	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Тайлант оны		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
0	ХАЦЭХ		9,313,740,724.00	10,938,272,200.00	11,904,588,031.00	(966,315,831.00)
1	Шатахууны зардал	1	38,742,574.00	45,508,558.00	45,319,660.00	188,898.00

**“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

3	Сэлбэг хэрэгсэл	3	34,721,156.00	11,065,943.00	10,937,560.00	128,383.00
4	Урсгал засвар	4	118,877,766.00	86,123,262.00	85,642,837.00	480,425.00
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	6	1,903,887,910.00	2,848,889,026.00	2,566,849,104.00	282,039,922.00
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	7	287,633,660.00	413,088,909.00	359,128,784.00	53,960,124.00
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	8	13,745,586.00	14,521,415.00	16,606,386.00	(2,084,971.00)
9	Ашиглалтын зардал-Дулаан	9	102,704,562.00	144,455,790.00	129,207,497.00	15,248,293.00
10	Ашиглалтын зардал-Ус	10	4,408,265.00	4,479,681.00	4,745,040.00	(265,359.00)
11	Албан томилолтын зардал	11	14,726,334.00	24,896,000.00	19,776,436.00	5,119,564.00
12	Конторын хангамжийн зардал	12	4,366,328.00	4,246,340.00	4,226,297.00	20,043.00
13	Харилцаа холбооны зардал	13	4,755,111.00	5,693,196.00	4,550,032.00	1,143,164.00
14	Харуул хамгаалалтын зардал	14	36,709,707.00	36,000,000.00	38,181,818.00	(2,181,818.00)
15	Хөдөлмөр хамгааллын зардал	15	54,315,744.00	61,990,000.00	61,929,272.00	60,728.00
16	Даатгалын зардал	16	13,538,775.00	13,516,190.00	13,327,410.00	188,780.00
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	18	280,555,649.00	377,482,527.00	407,694,940.00	(30,212,413.00)
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	19	43,780,475.00	45,056,400.00	29,173,121.00	15,883,279.00
21	Борлуулалт, маркетингийн зардал	21	5,426,517.00	6,500,000.00	4,540,355.00	1,959,645.00
23	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	23	11,800,000.00	15,600,000.00	15,600,000.00	-
24	Гадны үйлчилгээний хөлс	24	33,609,878.00	31,858,000.00	31,570,872.00	287,128.00
26	Сургалтын зардал	26	8,570,580.00	8,752,400.00	8,706,500.00	45,900.00
27	Найдваргүй авлагын зардал	27			2,880,412.00	(2,880,412.00)
28	Үйл ажиллагааны бусад зардал	28	1,170,069.00	1,242,200.00	1,166,680.00	75,520.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	29	3,018,046,648.00	4,200,965,836.00	3,861,761,014.00	339,204,823.00
30	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	30	216,865,526.00	240,953,500.00	240,704,886.00	248,614.00
31	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	31	862,898,715.00	798,256,500.00	879,916,107.00	(81,659,607.00)
	Элэгдлийн зардлын дүн	32	1,079,764,241.00	1,039,210,000.00	1,120,620,993.00	(81,410,993.00)
32	Үл хөдлөх хөрөнгийн татвар	33	20,726,858.00	15,691,745.00	22,133,712.00	(6,441,967.00)
33	АТӨЯХ-ийн албан татвар	34	906,806.00	1,127,600.00	808,258.00	319,342.00
34	Газрын төлбөр	35	1,234,784.00	2,071,700.00	177,980.00	1,893,720.00
35	Бусад татвар хураамж	36	25,289,791.00		84,520.00	(84,520.00)
	Орлогын албан татвараас бусад татварын дүн	37	48,158,239.00	18,891,045.00	23,204,470.00	(4,313,425.00)
36	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	39	5,202,688.00	147,595,079.00	4,758,551.00	142,836,528.00
37	Ажиллагсдын нийгмийн зардал	40	184,253,055.00	194,921,800.00	181,511,232.00	13,410,568.00
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	41	189,455,744.00	342,516,879.00	186,269,782.00	156,247,096.00
38	Үйл ажиллагааны бус зардал	42	405,392,744.00	275,881,500.00	430,850,282.00	(154,968,782.00)
	НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43/	45	14,054,558,339.00	16,815,737,459.00	17,527,294,572.00	(711,557,112.00)
40	Борлуулалтын орлого	46	9,883,672,606.00	11,498,430,589.00	12,688,323,002.00	1,189,892,413.00
41	Түгээх үйлчилгээ орлого	47	3,959,222,800.00	5,041,425,339.00	5,424,278,911.00	382,853,572.00
42	Бусад орлого	48	520,441,645.00	275,881,500.00	522,966,617.00	247,085,117.00
	НИЙТ ОРЛОГО /46+47-45/	49	14,363,337,051.00	16,815,737,427.00	18,635,568,531.00	1,436,977,531.00
43	ТАТВАРЫН ДАРААХИ АШИГ/АЛДАГДАЛ	50	277,900,841.00	-	997,446,563.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн зорилго нь “Стандартын цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх, борлуулах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж сүлжээний алдагдлыг багасган хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр соёлтой, чанартай үйлчилгээг үзүүлж, шударга харилцааг эрхэмлэн ажиллах”-д оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Эрдэнэт, Булган, Хархорин Өвөрхангай аймгийн 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч дамжуулан авч хэрэглэгчдэд түгээх” гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь ТУЗ-ийн 11 гишүүнтэй, цахилгаан шугам сүлжээ шуурхай үйлчилгээний алба, хэрэглэгчдэд үйлчлэх төв, захиргаа аж ахуйн гэсэн 3 алба хэсэгтэй, 94 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах нэгдүгээр гарын үсгийг Гүйцэтгэх захирал Ж.Уламбаяр (2024.01.01-2024.07.31, 2024.11.07-2024.12.31), Ерөнхий инженер Б.Бадамцэцэг (2024.07.31-2024.11.07), хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Хорлоо (2024.01.01-2024.04.05), нягтлан бодогч О.Ууганбаяр (2024.04.05.-2024.12.31) нар зурж нярваар Ш.Ундармаа ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт “Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг хэрэгцээ шаардлагын дагуу нэмэгдүүлж гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станц шинээр байгуулан албан байгууллага, айл өрхүүдийг шөнийн тарифт, ухаалаг тоолуурт шилжүүлэх” тухай заалт тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний зохицуулах хорооны 2024.11.01-ний өдрийн “Тариф батлах тухай” 632 дугаар тогтоолоор эрчим хүчний үнэ тариф шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа 2018 онд баталсан “Баянхонгор-Эрчим” цахилгаан түгээх компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь 2024 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон стандартын дагуу бэлтгэсэн байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 25,815,205.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 1,859,548.4 мянган төгрөг буюу 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	491,516.8	1,171,867.3	680,350.5
Авлага	1,253,690.8	2,041,490.3	787,799.6
Бараа материал	1,430,371.6	1,064,039.0	(366,332.6)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	406,066.6	592,616.7	186,550.1
Үндсэн хөрөнгө	19,926,702.8	20,496,479.2	569,776.4
Биет бус хөрөнгө	447,308.6	448,713.0	1,404.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>23,955,657.2</b>	<b>25,815,205.6</b>	<b>1,859,548.4</b>
Богино хугацаат өр төлбөр	189,361.4	368,817.7	179,456.2
Урьдчилж орсон орлого	11,242.2	30,669.2	19,427.0
Урт хугацаат өр төлбөр	468,461.7	427,882.4	(40,579.3)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,426,737.4	1,426,737.4	00.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,027,341.6	5,027,341.6	00.00
Эздийн өмчийн бусад хэсэг	18,673,854.9	19,377,652.8	703,798.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,841,342.0)	(843,895.4)	997,446.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>23,955,657.2</b>	<b>25,815,205.6</b>	<b>1,859,548.4</b>

Дээрх хүснэгтээс харахад, Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,171,867.3 мянган төгрөг болж 680,350.5 мянган төгрөгөөр өссөн нь тарифын үнэ өссөн, түгээх үйлчилгээний орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 2,041,490.3 мянган төгрөг болж өмнөх оноос 787,799.6 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнээс цахилгааны нэхэмжилсэн авлага 222,720.3 мянга, цахилгааны нэхэмжлэгдээгүй авлага 1,750,644.0 мянга, ХХОАТ-ын авлага 1,457.1 мянга, компани хоорондын авлага 66,668.9 мянган төгрөг байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 592,616.7 мянган төгрөг болж 186,550.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь урьдчилж төлсөн хөдөлмөр хамгааллын зардал 18,926.6 мянга, бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа 263,402.1 мянга, элэгдэж дуусаагүй механизмын дугуй 1,642.6 мянга, 10кВ-ын аваарын түр тэжээл 21,629.4 мянга, Шинэ суурьшлын бүсийн дэд станц, агаарын шугамтай холбоотой дуусаагүй 287,016.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг бүртгэсэн холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,064,039.0 мянган төгрөг болж 366,332.6 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 784,383.0 мянга, 6 дугаар хорооны дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн 649,979.1 мянган төгрөгийн тоноглол, материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 1,791,830.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр 8,705.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж, дутагдсан 158.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг төлүүлэх шийдвэр гаргасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 20,496,479.2 мянган төгрөг болж 569,776.4 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд өөрийн үйлдвэрлэсэн 1,538,655.3 мянга (барилга 620,635.9 мянга, 6 дугаар хорооны гудамжны гэрэлтүүлэг 52,533.7 мянга, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, тоноглол, төхөөрөмж 865,485.8 мянга), өөрийн хөрөнгөөр 133,851.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 47,498.8 мянган төгрөгийг Баянхонгор сумын ЗДТГ-аас шилжүүлэн авч, аймгийн ИТХ-ын даргын 2024.05.30-ны өдрийн “Хөрөнгө акталж данснаас хасах тухай” 35 дугаар захирамжаар үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1 нэр төрлийн 54,522.7 мянган төгрөгийн хөрөнгийг 13 дугаар цэцэрлэгт шилжүүлж, 32 нэр төрлийн 22,729.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 448,713.0 мянган төгрөг болж 1,404.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Эрчим хүчний аудитын баримт бичгийг бүртгэсэнтэй холбоотой.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 368,817.7 мянган төгрөг болж 179,456.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд: МҮОНТ-д 3,100.0 мянга, “Цэвэр хот” ОНӨААТҮГ-т 22,710.9 мянга, ААНОАТ-ын өр 95,782.8 мянга, НӨАТ-ын өр 233,413.6 мянга, ҮХЭХАТ-ын өр 12,353.5 мянга, бусад өр 14.6 мянга, цалингийн 1,442.5 мянган төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 427,882.4 мянган болж 40,579.3 мянган төгрөгийн зээлийн төлбөр төлөгдсөн байна. Зээлийн хүүгийн төлбөр 4,758.6 мянган төгрөгийг хүүгийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэн шилжүүлсэн байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 30,669.2 мянган төгрөг болж 19,427.0 мянган төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон цахилгааны орлого 13,561.2 мянга, гэрээт ажлын урьдчилгаа “Мастер зуурмаг” ХХК-аас 17,108.0 мянган төгрөг урьдчилж орсонтой холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 19,377,652.8 мянган төгрөг болж 703,797.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 997,446.6 мянган төгрөгөөр өсөж үнэ төлбөргүй хүлээн авсан 703,797.9 мянган төгрөгийн хөрөнгө нь эздийн өмчийг нэмэгдүүлсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ-ийн 2024.01.30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тус компанийн 2024 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна.

#### **3.5.1 Зорилтот түвшний төлөвлөлт**

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн ТУЗ-ийн 2024.01.30-ны өдрийн “2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” 02 дугаар тогтоолоор борлуулалтын орлогыг 10,670,043.0 мянга, түгээх үйлчилгээний орлогыг 4,841,073.2 мянга, нийт орлогыг 15,511,116.2 мянган төгрөгөөр, худалдаж авах цахилгаан эрчим хүчний зардалд 10,132,146.0 мянга, борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг 5,378,970.2 мянга нийт зардлыг 15,511,116.2 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардлыг 259,281.6 мянга, ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлыг 994,210.0 мянга, компанийн бүтэц орон тоог 94 ажилтнаар, цалингийн санг 3,018,230.6 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант хугацаанд Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний зохицуулах хорооны 2024.11.01-ний өдрийн “Тариф батлах тухай” 632 дугаар тогтоолоор эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотойгоор нэг удаа тодотгол хийн борлуулалтын орлогыг 828,387.6 мянга, ИЗТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлыг 45,000.0 мянга, цалингийн санг 155,100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.5.2 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 18,635,568.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 17,527,294.6 мянган төгрөгийн зардал гаргаж 997,446.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зорилтот түвшний гүйцэтгэлээр нийт орлого 18,635,568.5 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Үүнд борлуулалтын орлогыг 11,498,430.6 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс 12,688,323.0 мянга, түгээх үйлчилгээний орлогыг 5,041,425.3 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5,424,278.9 мянга, бусад орлогыг 275,881.5 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс 522,966.6 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нийт зардал 16,815,737.5 мянган төгрөг баталж, 17,527,294.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба үйл ажиллагааны зардлыг 339,204.8 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 23 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 726,916.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт №2. 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин (мянган төгрөг)

№	Зардлын төрөл	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Тайлант оны		Өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос	Төлөвлөгөө нөөс
1	ХАЦЭХ	9,313,740.7	10,938,272.2	11,904,588.0	(2,590,847.3)	(966,315.8)
2	Үйл ажиллагааны зардлын дүн	3,018,046.6	4,200,965.8	3,861,761.0	(843,714.4)	339,204.8
3	Элэгдлийн зардлын дүн	1,079,764.2	1,039,210.0	1,120,621.0	(40,856.8)	(81,411.0)
4	Орлогын албан татвараас бусад татварын дүн	48,158.2	18,891.0	23,204.5	24,953.8	(4,313.4)
5	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	189,455.7	342,516.9	186,269.8	3,186.0	156,247.1
6	Үйл ажиллагааны бус зардал	405,392.7	275,881.5	430,850.3	(25,457.5)	(154,968.8)
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>14,054,558.3</b>	<b>16,815,737.5</b>	<b>17,527,294.6</b>	<b>(3,472,736.2)</b>	<b>(711,557.1)</b>
7	Борлуулалтын орлого	9,883,672.6	11,498,430.6	12,688,323.0	(2,804,650.4)	1,189,892.4
8	Түгээх үйлчилгээ орлого	3,959,222.8	5,041,425.3	5,424,278.9	(1,465,056.1)	382,853.6
9	Бусад орлого	520,441.6	275,881.5	522,966.6	(2,525.0)	247,085.1
<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>14,363,337.1</b>	<b>16,815,737.4</b>	<b>18,635,568.5</b>	<b>(2,807,175.4)</b>	<b>1,436,977.5</b>
<b>ТАТВАРЫН ДАРААХИ АШИГ/АЛДАГДАЛ</b>		<b>277,900.8</b>	<b>(0.0)</b>	<b>997,446.6</b>		

Эх сурвалж: “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Гүйцэтгэх захирлын 2024.02.14-ний өдөр баталсан “Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд 654,858.6 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 тендер шалгаруулахаар төлөвлөсөн ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол оруулж 45,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 699,858.6 мянган төгрөгийн 7 тендер зарлахаар баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 7 тендер зарлаж Шатахууны тендерт “Ник” ХХК шалгарч 45,102.2 мянга, кабель нийлүүлэх тендерт “Цогт-онон” ХХК шалгарч 42,679.2 мянга, нэг фазын ухаалаг тоолуурыг тендерт “Мейжүрмэнт” ХХК шалгарч 165,000.0 мянга, тоолуур хэмжих хэрэгслийн явуулын лабораторийн тээврийн хэрэгсэл нийлүүлэх тендерт “Болд суварга” ХХК шалгарч 58,490.0 мянга, SEL-751A РЕЛЕ, 35кВ вакуум таслуур нийлүүлэх тендерт “Эко нью теч” ХХК шалгарч 88,000.0 мянга, авто кран нийлүүлэх тендерт “Бүдума” ХХК шалгарч 169,700.0 мянга, үйлчилгээний тээврийн хэрэгсэл нийлүүлэх тендерт “Бүдума” ХХК шалгарч 37,700.0 мянган төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 17,527.294.6 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 854,500.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 175,272.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 122,691.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 23,000.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 157 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 118,664.9 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 6,545,469.0 мянган төгрөгийн 69 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 12,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 12,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 12,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгч, "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	12,000.0	1	12,000.0	100
Зөвлөмж	1	0.0	1	0.0	100
Нийт дүн	2	12,000.0	2	12,000.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн ИТХ-ын даргын 2024.04.03-ны өдрийн 1а/80 дугаар албан бичгээр "Баялаг бүтээгч-Баянхонгор" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдээ дэвшилтэт техник, тоног төхөөрөмж, технологитой танилцуулах зорилгоор БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдсан "Кантон фэйр-2024" үзэсгэлэн яармагт 2 албан хаагчийг хамруулан 5,000.0 мянган төгрөгийг зарцуулсан ба Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

2. Гүйцэтгэх захиралд БНХАУ-д сэргээгдэх эрчим хүчний зөвлөгөөнд оролцоход гадаад томилолтын зардал болон онгоцны тийзийн зардалд 4,531.6

мянган төгрөгийг зарцуулсан асуудлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн аудитаар авч үзэх шаардлагатай.

3. Тус байгууллагад шинээр барилга ашиглалтад орсонтой холбоотойгоор одоо ашиглаж буй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн байрыг ашиглахгүй болж байгаа тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн аудитаар байрыг цаашид ямар зориулалтаар ашиглах эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,150.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 150.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 23,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 23,150.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 122,691.1 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 99,541.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь 2024.10.01-ны өдөр “Байгууллагын ажиллагсад нэг удаагийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх тухай” Б/82 дугаар тушаалаар өөр өөртөө шийдвэр гарган 150.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөр өөртөө шийдвэр гарган авсан түлшний хөнгөлөлт 150.0 мянган төгрөгийг ерөнхий инженерээр орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Гүйцэтгэх захирлын 2024 оны 02 дугаар сарын 21-ний “Хөрөнгө зарцуулсан тухай” Б/31 дүгээр тушаалаар эмэгтэйчүүдийн чадавхыг нэмэгдүүлэх үүднээс мэдлэг мэргэжил дээшлүүлэх, семинар зөвлөгөөнд оролцох, туршлага судлах үйл ажиллагаанд үйл ажиллагааны бус зардлаас 23,000,000 төгрөгийг зарцуулах шийдвэр гаргаж байгууллагын 23 эмэгтэй албан хаагчид тус бүр 1,000,000 нийт 23,000,000 төгрөгийг ажилчдын нийгмийн зардалд гэж гүйлгээг хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гүйцэтгэх захирлын 2024 оны 02 дугаар сарын 21-ний "Хөрөнгө зарцуулсан тухай" Б/31 дүгээр тушаалаар эмэгтэйчүүдийн чадавхыг нэмэгдүүлэх үүднээс мэдлэг мэргэжил дээшлүүлэх, семинар зөвлөгөөнд оролцох, туршлага судлах үйл ажиллагаанд үйл ажиллагааны бус зардлаас 23,000,000 төгрөгийг зарцуулах шийдвэр гаргаж байгууллагын 23 эмэгтэй албан хаагчид тус бүр 1,000,000 нийт 23,000,000 төгрөгийг ажилчдын нийгмийн зардалд гэж гүйлгээг хийсэн байна.	1	23,000.0	-	-	1	23,000.0	-	-
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь 2024.10.01-ны өдөр "Байгууллагын ажиллагсад нэг удаагийн дэмжлэг, буцалтгүй тусламж үзүүлэх тухай" Б/82 дугаар тушаалаар өөр өөртөө шийдвэр гарган 150.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт авсан байна.	1	150.0	1	150.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>23,150.0</b>	<b>2</b>	<b>150.0</b>	<b>1</b>	<b>23,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>

-----oO-----